



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХАА-н Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/30/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2022 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: В.Жавзмаа Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХАА	Хөдөө аж ахуй

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

Аудитын санал дүгнэлт № 04
танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ХАА-Н
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Ц.ОРХОНЧИМЭГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ХАА-н Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ХАА-н Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>16,517,020.00</u>	<u>23,013,970.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	16,517,020.00	23,013,970.00
351	Түүхий эд материал	8,570,500.00	11,545,950.00
35110	Тусгай зориулалттай материал	8,570,500.00	11,135,950.00
35130	Эм боох материал	-	410,000.00
354	Хангамжийн материал	5,946,520.00	11,468,020.00
35410	Бичиг хэргийн материал	568,000.00	2,549,300.00
35420	Аж ахуйн материал	5,378,520.00	8,178,720.00
35440	Түлш, шатах тослох материал	-	740,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>558,410,742.83</u>	<u>550,493,408.75</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	558,410,742.83	550,493,408.75
392	Биет хөрөнгө	429,154,562.83	421,237,228.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	65,252,456.42	71,604,956.42
39202	Хуримтлагдсан элэгдэл	(9,046,059.12)	(13,569,088.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	51,818,000.00	46,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(50,068,000.26)	(44,750,000.30)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	103,715,350.00	75,407,983.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(65,888,720.30)	(40,657,539.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,560,600.00	22,696,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,254,877.91)	(18,061,596.50)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	294,590,964.00	294,590,964.00
39217	Ном	27,974,850.00	27,974,850.00
393	Биет бус хөрөнгө	129,256,180.00	129,256,180.00
39303	Бусад биет бус хөрөнгө	129,256,180.00	129,256,180.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>574,927,762.83</u>	<u>573,507,378.75</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>574,927,762.83</u>	<u>573,507,378.75</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	574,927,762.83	573,507,378.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	307,827,906.00	307,827,906.00
51101	Өмч: - төрийн	307,827,906.00	307,827,906.00
512	Хуримтлагдсан үр дүн	226,669,585.94	225,249,201.86
51210	Өмнөх үеийн үр дүн	226,669,585.94	226,669,585.94
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,420,384.08)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	40,430,270.89	40,430,270.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>574,927,762.83</u>	<u>573,507,378.75</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	995,915,920.00	1,031,707,973.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,804,820.00	23,558,873.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,804,820.00	23,558,873.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,804,820.00	23,558,873.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,256,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,529,820.00	18,302,873.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	983,111,100.00	1,008,149,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	983,111,100.00	1,008,149,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	983,111,100.00	1,008,149,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,018,049,455.14	1,029,628,357.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,018,049,455.14	1,029,628,357.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	854,829,780.47	934,275,904.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	592,850,158.92	678,504,887.07
210101	Үндсэн цалин	401,890,194.80	444,441,940.48
210102	Нэмэгдэл	113,473,111.92	154,861,039.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,091,500.00	29,336,400.00
210104	Урамшуулал	49,395,352.20	49,865,507.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,810,808.92	87,836,058.35
210201	Тэтгэврийн даатгал	51,365,758.86	62,387,755.37
210202	Тэтгэмжийн даатгал	6,043,030.60	6,926,053.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,757,143.70	5,433,322.68
210204	Ажилгүйдлийн даатгал	1,058,624.68	1,185,205.96
210205	Эрүүл мэндийн даатгал	10,586,251.08	11,903,720.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,631,590.91	97,240,759.06
210301	Гэрэл, цахилгаан	2,209,469.07	3,403,985.75
210302	Түлш, халаалт	10,898,150.97	13,982,043.88
210303	Цэвэр, бохир ус	3,633,970.87	1,854,729.43
210304	Байрны түрээс	75,890,000.00	78,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,870,916.58	18,478,142.89
210401	Бичиг хэрэг	3,330,900.00	2,336,550.00
210402	Тээвэр, шатахуун	6,000,000.00	6,035,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,364,366.58	3,831,362.89
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,192,050.00	2,946,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,296,600.00	3,329,230.00
2105	Нормативт зардал	5,978,300.00	2,876,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,464,300.00	2,876,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,926,000.00	1,635,500.00
210604	Урсгал засвар	3,926,000.00	1,635,500.00
2107	Томилолт, зочны зардал	952,300.00	674,300.00
210702	Дотоод албан томилолт	952,300.00	674,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,309,450.00	2,737,230.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	396,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,142,250.00	1,561,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,200.00	101,480.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	130,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,500,255.14	44,292,727.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,323,900.00	19,405,020.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,176,355.14	24,887,707.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	163,219,674.67	95,352,452.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,604,984.00	69,928,915.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	46,845,794.00	64,637,856.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,045,500.00	5,291,059.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,614,690.67	25,423,537.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,614,690.67	25,423,537.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(22,133,535.14)</u>	<u>2,079,615.92</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	3,500,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,500,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(3,500,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(22,133,535.14)</u>	<u>(1,420,384.08)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	307,827,906.00	40,430,270.89	248,803,121.08	597,061,297.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	307,827,906.00	40,430,270.89	248,803,121.08	597,061,297.97
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			(22,133,535.14)	(22,133,535.14)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	307,827,906.00	40,430,270.89	226,669,585.94	574,927,762.83
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	307,827,906.00	40,430,270.89	226,669,585.94	574,927,762.83
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	307,827,906.00	40,430,270.89	226,669,585.94	574,927,762.83
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт, бууралт				

Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			(1,420,384.08)	(1,420,384.08)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	307,827,906.00	40,430,270.89	225,249,201.86	573,507,378.75

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>990,719,931.00</u>	<u>1,022,657,462.21</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,275,000.00	11,256,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,275,000.00	11,256,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,275,000.00	11,256,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,256,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,275,000.00	3,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	988,444,931.00	1,011,401,462.21
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	983,111,100.00	1,008,149,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	983,111,100.00	1,008,149,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,333,831.00	3,252,362.21
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,333,831.00	3,252,362.21
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>990,719,931.00</u>	<u>1,022,657,462.21</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	990,719,931.00	1,022,657,462.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	822,166,425.33	924,052,647.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	592,850,158.92	678,504,887.07
210101	Үндсэн цалин	408,875,517.31	445,197,246.45
210102	Нэмэгдэл	106,687,642.16	154,125,533.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,091,500.00	29,316,600.00
210104	Урамшуулал	49,195,499.45	49,865,507.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,810,808.92	87,836,058.35
210201	Тэтгэврийн даатгал	51,365,758.86	62,387,755.37
210202	Тэтгэмжийн даатгал	6,043,030.60	6,926,053.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,757,143.70	5,433,322.68
210204	Ажилгүйдлийн даатгал	1,058,624.68	1,185,205.96
210205	Эрүүл мэндийн даатгал	10,586,251.08	11,903,720.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,631,590.91	97,240,759.06
210301	Гэрэл, цахилгаан	2,209,469.07	3,403,985.75
210302	Түлш, халаалт	10,898,150.97	13,982,043.88
210303	Цэвэр, бохир ус	3,633,970.87	1,854,729.43
210304	Байрны түрээс	75,890,000.00	78,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,183,916.58	19,726,642.89
210401	Бичиг хэрэг	3,330,900.00	2,358,050.00

210402	Тээвэр, шатахуун	6,000,000.00	6,590,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,364,366.58	3,831,362.89
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,063,250.00	3,618,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,425,400.00	3,329,230.00
2105	Нормативт зардал	5,978,300.00	5,414,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,464,300.00	3,106,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,514,000.00	2,308,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,926,000.00	7,988,000.00
210604	Урсгал засвар	3,926,000.00	7,988,000.00
2107	Томилолт, зочны зардал	952,300.00	674,300.00
210702	Дотоод албан томилолт	952,300.00	674,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,309,450.00	2,737,230.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	396,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,142,250.00	1,561,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,200.00	101,480.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	130,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,523,900.00	23,930,270.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,523,900.00	23,930,270.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	168,553,505.67	98,604,814.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,938,815.00	73,181,277.21
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,333,831.00	3,252,362.21
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	46,845,794.00	64,637,856.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,045,500.00	5,291,059.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,614,690.67	25,423,537.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,614,690.67	25,423,537.63
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,014,149,100.00	988,725,562.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,014,149,100.00	988,725,562.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	944,161,500.00	918,796,647.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	696,612,300.00	678,504,887.07
210101	Үндсэн цалин	454,249,800.00	445,197,246.45
210102	Нэмэгдэл	161,604,600.00	154,125,533.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,903,000.00	29,316,600.00

210104	Урамшуулал	48,854,900.00	49,865,507.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,326,000.00	87,836,058.35
210201	Тэтгэврийн даатгал	66,377,600.00	62,387,755.37
210202	Тэтгэмжийн даатгал	6,987,100.00	6,926,053.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,589,700.00	5,433,322.68
210204	Ажилгүйдлийн даатгал	1,397,400.00	1,185,205.96
210205	Эрүүл мэндийн даатгал	13,974,200.00	11,903,720.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,665,000.00	97,240,759.06
210301	Гэрэл, цахилгаан	3,421,200.00	3,403,985.75
210302	Түлш, халаалт	14,362,200.00	13,982,043.88
210303	Цэвэр, бохир ус	1,881,600.00	1,854,729.43
210304	Байрны түрээс	78,000,000.00	78,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,967,100.00	19,726,642.89
210401	Бичиг хэрэг	2,358,700.00	2,358,050.00
210402	Тээвэр, шатахуун	6,594,200.00	6,590,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,063,100.00	3,831,362.89
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,618,100.00	3,618,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,333,000.00	3,329,230.00
2105	Нормативт зардал	5,421,600.00	5,414,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,106,300.00	3,106,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,315,300.00	2,308,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,988,000.00	7,988,000.00
210604	Урсгал засвар	7,988,000.00	7,988,000.00
2107	Томилолт, зочны зардал	761,800.00	674,300.00
210702	Дотоод албан томилолт	761,800.00	674,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,738,600.00	2,737,230.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	396,800.00	396,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,562,000.00	1,561,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,100.00	101,480.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,700.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,681,100.00	18,674,270.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,681,100.00	18,674,270.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,987,600.00	69,928,915.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,987,600.00	69,928,915.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	64,638,100.00	64,637,856.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,349,500.00	5,291,059.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,014,149,100.00	1,014,149,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,008,149,100.00	1,008,149,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,008,149,100.00	1,008,149,100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,000,000.00	6,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	3,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	3,000,000.00

61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	51.00	51.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	236.00	252.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	235.00	252.00
630001	Төрийн өмчит ЕБС	235.00	252.00
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	1.00	1.00
632001	Төрийн өмчит МСҮТ	1.00	1.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	51.00	51.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	28.00	28.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	23.00	23.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	5,256,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	5,256,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	5,256,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,256,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,256,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ХАА-н Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

ХАА-н Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

ХАА-н Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант оны хичээлийн жилд "Чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлэх" зорилго дэвшүүлж, хэрэгжилтийг хангах дараах зорилт дэвшүүлсэн байна.

- Томоохон бүтээн байгуулалт, хөгжлийн бодлоготой уялдуулан сургалтын байгууллагыг төрөлжүүлэн хөгжүүлж, сургалтын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын стандарт, хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх, цахим сургалт-үнэлгээний арга зүй, аргачлалыг боловсронгуй болгоно.
- Суралцагчийн хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, сурах үйл ажиллагаа, идэвх оролцоо, тэгш хүртээмжтэй байдлыг хангах замаар чанартай мэргэжил боловсролыг олгоно.
- Сургалтыг үйлдвэрлэл, үйлчилгээтэй хослуулах замаар чанар хүртээмжийг дээшлүүлж төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, хяналтын механизмыг сайжруулна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод чанарын баталгаажуулалт, статистик хариуцсан ахлах ажилтан ажилладаг хэдий ч тухайн ажилтан чиг үүргээ хэрэгжүүлснээр тодорхой үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ХАА-н Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 10,141.5 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 1,014,149.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,141.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,099.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

ХАА-н Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,420.4 мянган төгрөгөөр буюу 0.24 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	
Бараа материал	16,517.0	23,014.0	6,497.0
Үндсэн хөрөнгө	558,410.7	550,493.4	(7,917.3)
Нийт хөрөнгө	574,927.7	573,507.4	(1,420.3)
Өр төлбөр	0.0	0.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	574,927.7	573,507.4	(1,420.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	574,927.7	573,507.4	(1,420.3)

Бараа материалын данс 23,014.0 мянган төгрөг болж 6,497.0 мянган төгрөгөөр өссөн нь хичээл үйлдвэрлэлийн зардлаас худалдан авсан хөдөлмөр хамгааллын хувцас, самбар болон тусгай зориулалтын материал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 550,493.4 мянган төгрөг болж 7,917.3 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2021 оны 577 дугаар тогтоолоор 76,497.1 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 573,507.4 мянган төгрөг болж 1,420.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

ХАА-н Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 35,792.0 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар, нийт зардал өмнөх оноос 11,578.9 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

ХАА-н Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,156,534.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,156,534.0 сая төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 133,183.1 мянган төгрөгөөр бууруулан 1,023,350.9 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 2 удаа тодотгол хийж 9,201.8 мянган төгрөгөөр бууруулж, 1,014,149.1 мянган төгрөгөөр баталжээ. Цалингийн зардлыг бууруулж тодотгол хийсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх мэргэжлийн боловсрол хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,008,149.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 6,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 988,725.6 мянган төгрөгийг зарцуулж, 25,243.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 988,725.6 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 18,107.4 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 6,489.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 424.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 240.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 5,256.0 мянган төгрөгийн түр сургалтын төлбөр 5,256.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 5,256.0 мянган төгрөгийг түр сургалтын цалин, гэрчилгээний үнэ, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын самбар авахад зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй хэдий ч санхүүгийн тайланд 2014 онд дуусаагүй барилга бүртгэсэн байна. Захиалагч ХНХЯ барилгын явцад хяналт хэрэгжүүлж, санхүүжилт олгож байгаа нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 16.3-т “Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

ХАА-н Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2021 онд нийт 1,202,496.7 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 947,940.7 мянган төгрөгийн 134 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлж, 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Аудитын явцад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 234,465.5 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зардлын 25,852.5 мянган төгрөгийн 4 гүйлгээ, төсөв өмч, хөрөнгө

зарцуулах 2,238.5 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүйг залруулсан болно. Мөн шилэн дансанд мэдээлэх мэдээллийн талаар талбар бүрээр зөвлөгөө өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин хичээл үйлдвэрлэлийн зардлаас авсан зарим бараа материал цахим төлбөрийн е-баримтгүй зөвхөн нэхэмжлэх, зарлагын баримттай байгаа болон шатахууны тооцоо бодсон баримт, жолоочийн тооцооны хуудас бүрэн хөтлөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.5, 13.6 дахь заалт, Сангийн сайдын 2017 онд баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2,632.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 231.8 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	2	2,632.6	2	2,632.6			
Албан шаардлага							
Зөвлөмж	3	231.8	3	231.8			
Нийт дүн	5	2,864.4	5	2,864.4			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, урсгал засварын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 384,285.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 271,398.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 104,194.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 8,692.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Бараа материалын орлогын журналаас гүйцэтгэлийн материаллаг байдлаас давсан гүйлгээг тулгахад ногооны хашаа засварын 6,352.5 мянган төгрөгийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, сургалтын хэрэглэгдэхүүнээр ашиглаж буй 2,489.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаар тайлагнасныг холбогдох дансанд залруулж тайлагнуулав.

Мөн шилэн дансанд мэдээлэх цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 234,465.5 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зардлын 25,852.5 мянган төгрөгийн 4 гүйлгээ,

төсөв өмч, хөрөнгө зарцуулах 2,238.5 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүйг залруулж, мэдээлсэн болно.

4.3 Албан шаардлага

Тайлант оны батлагдсан төсвөөс үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зарим зардлаас 10-аас доошгүй хувийн хэмнэлт үүсгэхээр тооцож зарцуулах байсан хэдий ч хэмнэлт үүсгээгүй, байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй зарим хөрөнгийг эд хариуцагчид хариуцуулж карт хөтлөөгүй, баталгаажуулаагүй тул 2 албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын хичээл үйлдвэрлэлийн зардлаас авсан зарим бараа материал цахим төлбөрийн е-баримтгүй зөвхөн нэхэмжлэх, зарлагын баримттай байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.5 дахь заалт, Сангийн сайдын 2017 онд баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл хангасан ажил гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгах.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Үндсэн бус үйл ажиллагааны орлогыг хүнсний ногоо борлуулсан тухай бүр кассын орлогоор бүртгэхгүйгээр харилцах дансанд төвлөрүүлж, холбогдох тодруулга тайлбарыг хийгээгүй нь Сангийн сайдын 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.9-д “мөнгөн кассаар дамжуулан хийгдэх гүйлгээ бүрд орлого, зарлагын баримтыг бичиж байна. Харин тусгай кассаар дамжин төвлөрсөн журмаар орох бараа, ажил үйлчилгээ болон үзвэр, үйлчилгээний орлого, цалин, тэтгэмж болон тусгай жагсаалтаар гаргах зарлага зэрэгт орлого, зарлагын төрөл тус бүрээр нэгдсэн нэг баримт бичнэ”, 3.12-т “эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана” гэж заасныг мөрдөөгүйтэй холбоотой байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн бус үйл ажиллагааны орлогыг борлуулалт хийсэн тухай бүр орлогыг хэрхэн цуглуулж төвлөрүүлэн, санхүүгийн тайлангийн тодруулга тайлбар хэсэгт тайлагнах.

3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв, бүрэн хөтлөөгүй, тооцоо бодсон баримт хангалтгүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.5, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, Сангийн сайдын 2017 онд баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шатахуун зарцуулалтын анхан шатны баримтыг заавар аргачлалын дагуу хөтөлж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлж, үр дүнг үнэлэх.

4. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд мэдээлэх 149 талбарын мэдээллээс 134 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 15 мэдээллийг хугацаа хоцроосон бөгөөд аудитын явцад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 234,465.5 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зардлын 25,852.5 мянган төгрөгийн 4 гүйлгээ, төсөв өмч, хөрөнгө зарцуулах 2,238.5 мянган төгрөгийн 2 гүйлгээг залруулсан нь Шилэн дансны тухай хуулийн 7.1-д “шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”; 7.1.1-д “засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан”; 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэж заасныг мөрдөөгүйтэй холбоотой байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлж, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, хариуцлагыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХАА-н мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	8	384,285.8	3	271,398.5			2	104,194.4	4	8,692.9